



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/298

Арвайхээр

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.5 “б”, 29.2 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2014 оны “Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг батлах тухай” 415 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Аймгийн “Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тооны дээд хязгаар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Бүтэц, орон тооны дээд хязгаарыг баримтлан, Эрүүл мэндийн газрыг нийт 38 орон тоогоор, түүнээс нэр бүхий 18 ажил, албан тушаалыг төрийн захиргааны, 20 ажил, албан тушаалыг төрийн үйлчилгээний ангиллаар тогтоон, хууль эрх зүйн актын хүрээнд үндсэн цалин бусад нэмэгдэл цалинг батлан мөрдөж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Н.Энхцэцэг)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын “Эрүүл мэндийн газрын дүрэм, бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай” 2019 оны А/53 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г. ГАНБОЛД

011100649

Аймгийн Засаг даргын 2019 оны 05
дүгээр сарын 07...ны өдрийн А.298 дугаар
захирамжийн хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТООНЫ
ДЭЭД ХЯЗГААР**

Эрүүл мэндийн газрын дарга /ТЗ/

Нэг. Удирдлага төлөвлөлтийн хэлтэс, орон тоо-6

1. Хэлтсийн дарга /ТЗ/
2. Хууль эрх зүй, дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн /ТЗ/
3. Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, мэргэжлийн зөвшөөрөл, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн /ТЗ/
4. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, шагнал, ёс зүй хариуцсан мэргэжилтэн /ТЗ/
5. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан мэргэжилтэн /ТҮ/
6. Олон нийт, хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан /ТҮ/

Хоёр. Эмнэлгийн тусламжийн хэлтэс, орон тоо- 7

1. Хэлтсийн дарга /ТЗ/
2. Яаралтай, гамшгийн үеийн тусламж, цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, эмнэлгээс шалтгаалах халдварын асуудал хариуцсан мэргэжилтэн /ТҮ/
3. Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, оношилгоо, эмчилгээний технологи мөрдөлт хариуцсан тусламж хариуцсан мэргэжилтэн /ТҮ/
4. Хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /ТҮ/
5. Сувилахуйн болон хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /ТҮ/
6. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж хариуцсан мэргэжилтэн /ТЗ/
7. Эмийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /ТЗ/

Гурав. Хяналт- шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс, орон тоо-4

1. Хэлтсийн дарга /ТЗ/
2. Эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн /ТЗ/
3. Статистик мэдээллийн ажилтан /ТҮ/
4. Мэдээллийн технологи, телемедицин хариуцсан мэргэжилтэн /ТЗ/

Дөрөв. Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс, орон тоо-7

1. Хэлтсийн дарга /ТЗ/
2. Нөхөн үржихүй, өсвөр үеийнхний эрүүл мэндийн тусламж, лабораторийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн /ТЗ/
3. Сум, өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, ахмад настны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн /ТЗ/
4. Орчны эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, гэдэсний болон бэлгийн замаар дамжих халдварын тандалт сэргийлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн /ТЗ/
5. Халдварт бус өвчний тандалт, сэргийлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн /ТЗ/

6. Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн /ТЗ/
7. Халдварт өвчин, дархлаажуулалтын мэдээ, мэдээлэл хүйтэн хэлхээ хариуцсан ажилтан /ТҮ/

Тав. Захиргаа, санхүү, нийтлэг үйлчилгээний алба, орон тоо-13

1. Албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /ТҮ/
2. Эдийн засагч /ТҮ/
3. Нягтлан бодогч /ТҮ/
4. Архив, бичиг хэргийн ажилтан /ТҮ/
5. Даргын туслах /ТЗ/
6. Жолооч-2 /ТҮ/
7. Үйлчлэгч-2 /ТҮ/
8. Жижүүр-4 /ТҮ/

Бүгд орон тоо-38

1. Эрүүл мэндийн газрын дарга -1
2. Удирдлага төлөвлөлтийн хэлтэс-6
3. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс-7
4. Хяналт шинжилгээ, үнэлгээ, статистик мэдээллийн хэлтэс-4
5. Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс-7
6. Захиргаа, санхүү, нийтлэг үйлчилгээний алба-13